



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  Х.ГАН-ОЧИР

НИЙЛҮҮЛЭГЧ:
“АНАР ПРИНТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
 А.МӨНХЦЭЦЭГ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ГЭРЭЭ /БАГЦ-01/

Дугаар № ХӨ-2020/ЗДТГ-01 Б/01

Хөвсгөл аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Х.Ган-Очир (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Анар принт ххк-ийн захирал А.Мөнхцэцэг (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 02сарын 28-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь ХӨ-2020/ЗДТГ-01 Б/01 дугаартай тендерийн 1 дугаар багцын Бичиг хэргийн материал нийлүүлэх ажил -г (цаашид “бараа” гэх) 9715000 /есөн сая долоон зуун арван таван мянга / төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

2. Захиалагч нь барааны нийлүүлэлтийн 9715000 төгрөгийг төсвийн урсгал зардлын хөрөнгөөр санхүүжүүлнэ.

3. Нийлүүлэгч нь материалыг 2020 оны 02 дугаар сарын 28-ноос 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

4. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.


7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

8. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, түүний хавсралтанд заасан эрх, үүрэг хүлээнэ.

9. Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.


10. Гэрээг 4 хувь үйлдэж талууд болон холбогдох байгууллагууд тус бүр нэг хувийг хадгална.

ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН НУА-НЫ
ДАРГА  Л. БАТБАЯР


Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
8-р баг,
Аймгийн ЗДТГ-ын "а" байр
Факсын дугаар: 70382100
Утасны дугаар: 99504540,

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА  Б. БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын "А" байр
Утасны дугаар: 99034719, 70388849
Факсын дугаар: 70388849

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

"АНАР ПРИНТ" ХХК-ИЙН
МЕНЕЖЕР  Х. ХАСБААТАР

Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Утасны дугаар: 88087142
Харилцагч банкны нэр,
Төрийн банк: 5890915472
Регистрийн дугаар: 4131673

ХӨ-2020/ЗДТГ-01 Б/01 ДУГААРТАЙ
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Нийлүүлсэн барааны бүрэн бүтэн байдлыг хангаж байгаад шалгалт хийж, хүлээн авах эсэхийг ашиглагч байгууллагаас томилсон ажлын хэсэг хүлээнэ авна. Ажлын хэсэг нь гэрээнд тусгагдсан бараа бүрэн бүтэн эсэх, техникийн тодорхойлолтын дагуу бараа нийлүүлсэнийг хянан үзнэ.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт,
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
 - 6) Гаалийн баримт бичиг
 - 7) Техникийн паспорт, ашиглалтын заавар
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат засварын хугацаа ашиглагч байгууллага хүлээн авсанаас хойш 1 жил байна.
- Ашиглагчаас шалтгаалаагүй техникийн эвдрэл, гэмтэл, хохирлыг нийлүүлэгч баталгаат засварын хугацаанд бүрэн хариуцна. Бичиг хэргийн материал нь чанарын баталгааны хугацаанд ашиглагчаас шалтгаалж техникийн эвдрэл, гэмтэл, хохирлыг нийлүүлэгч хариуцахгүй.
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. Барааг нийлүүлж ашиглагч хүлээн авсанаас хойш төлбөрийг шилжүүлнэ.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: *Гэрээний үнийн дүнгийн 0,5 хувь*
Алдангийн нийт дүн: *Гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байх.*
- ХӨ-2020/ЗДТГ-01 Б/01 дугаартай гэрээний тусгай нөхцлийн 1.1.9-д заасныг мөрдөнө.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛИЙГ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИАЛАГЧ:.....*1886*.....
НИЙЛҮҮЛЭГЧ:.....*Монгол*.....

НЭГ. ЗАХИАЛАГЧ, НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагч, гүйцэтгэгч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, энэ гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөлд зааснаас гадна дараах үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

1.1. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1.1.1. Захиалагч нь бараа нийлүүлэх гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ дүгнэх үүрэг бүхий төслийн менежерийн багийг 3-аас доошгүй мэргэшсэн этгээдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

1.1.2. Төслийн менежерийн баг нь нийлүүлэгчээс бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлсэн барааг дор дурьдсан баримт бичгийг үндэслэн хүлээн авна. Үүнд:

- а. Барааны гарал үүслийн гэрчилгээний хуулбар
- б. Барааны техникийн тодорхойлолт
- в. Гадаад улсаас Монгол улсад импортлож буй барааны гаалийн бичиг
- г. Бусад холбогдох баримт бичиг

1.1.3. Захиалагч нь барааны чанар стандартыг тодорхойлуулах, техникийн тодорхойлолтонд заасан стандарт шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлэгчээс авах эрхтэй

1.1.4. Бараа, материалын баталгаат хугацааны дотор бараа, түүнийг хүлээн авах ашиглах үед гэмтэл, дутагдал илэрвэл бэлтгэн нийлүүлэгчийн төлөөлөгчийг заавал дуудна.

1.1.5. Нийлүүлсэн бараа нь захиалагчийн техникийн тодорхойлолтонд заасан чанарын шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзаж өөр бараагаар солиулах эрхтэй

1.1.6. Нийлүүлэгчээс хүлээн авсан барааны элэгдэл, хорогдлыг захиалагч /ашиглагч/ бүрэн хариуцна.

1.1.7. Барааны төлбөрийг олгоход шаардагдах 1.2.5-д заасан баримт бичгийг захиалагч хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор барааны төлбөрийг нийлүүлэгчид төлнө.

1.1.8. Барааг захиалагчийн ажлын талбайд хүлээн авна.

1.1.9. Захиалагч нь барааны төлбөрийг гэрээнд заасан эцсийн хугацаанд төлөөгүй нөхцөлд гэрээний үнийн төлөгдөөгүй үлдэгдлийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг төлбөрийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлнө. Нийт алдангийн хэмжээ нь гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй

1.1.10. Захиалагч нь гэрээний үүргээ тоо чанарын хувьд давуулан онцгой чанартай сайн гүйцэтгэсэн нийлүүлэгчийг “чансаа” өндөр гүйцэтгэгчийн бүртгэлд бүртгүүлэх, төрийн байгууллагаас олгодог шагнал урамшуулалд тодорхойлох, эсхүл гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн нийлүүлэгчийн талаархи мэдээлэл, нотлох баримтыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлэн тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.

1.2. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1.2.1. Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх чанарын баталгааг захиалагчийн заасан дансанд байршуулна.

1.2.2. Өөрийн тендерт санал болгосон техникийн тодорхойлолт бүхий гэрээний хавсралтанд заасан бараа нийлүүлэх хуваарийн дагуу захиалагчийн ажлын талбайд хүргэнэ.

1.2.3. Барааг хүлээлгэн өгөхөд шаардлагатай гаалийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн байх

1.2.4. Барааг захиалагчийн томилсон төслийн мененжерийн багт хүлээлгэн өгч, барааг нийлүүлсэн тухай актыг баталгаажуулна.

1.2.5. Нийлүүлсэн барааны санхүүжилт авахад шаардлагатай ГЕН-ийн 1.2-д заасан баримт бичгийг захиалагчид хүргүүлнэ.


1.2.6. Тээвэрлэлтийн явцад бараа эвдрэх, гэмтэх бүх эрсдэлийг нийлүүлэгч хариуцна.

1.2.7. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ биелүүлэх, барааг нийлүүлэлтийн хуваарийн дагуу хүлээн авах, барааны төлбөрийг төлөхийг захиалагчаас шаардах эрх эдлэнэ.

1.2.8. Нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас хоцроосон болон огт нийлүүлээгүй барааны үнийн дүнгээс хоногт 0,5 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ нь гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦЛИЙН ХАВСРАЛТЫГ ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИАЛАГЧ:



НИЙЛҮҮЛЭГЧ:



2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ
ЗӨВЛӨМЖ

2020.02.20

Мөрөн

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичиг хэрэг, хэвлэмэл хуудас нийлүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгарууллаа.

Уг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахад бичиг хэргийн материал нийлүүлэх 01 дүгээр багцад "Анар принт" ХХК 9,715,000 төгрөг, Хэвлэмэл хуудас нийлүүлэх 02 дугаар багцад "Хөвсгөл Хонгор" ХХК 3,461,300 төгрөгийн үнийн саналтай тендерүүдийг ирүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичиг хэрэг, хэвлэмэл хуудас нийлүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерт оролцсон 01 дүгээр багцад "Анар принт" ХХК 9,715,000 (Есөн сая долоон зуун арван таван мянган) төгрөгийн, 02 дугаар багцад "Хөвсгөл Хонгор" ХХК 3,461,300 (Гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга гурван зуун) төгрөгийн саналтай тендерүүд ирүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар 28.7.4 дэх заалтыг хангаж байгаа тул гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Иймд "Анар принт" ХХК, "Хөвсгөл Хонгор" ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулна уу.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА




С.БАТХУЯГ


Л.ЗАНДАНМЯДАГСҮРЭН

М.Цагда
А.Батбилэг
Хүндэтгэгч
2020.02.20

Бараа материалын үнийн санал
1-р багц бичиг хэргийн материал

Барааны тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнийн үнэ	Нийт үнэ
Бичгийн цаас	Боодол	640	10000	6400000
Самсунг 4729 103l	ш	7	65000	455000
Самсунг 4824 209s	ш	4	65000	260000
Канон MF4350/FX9l	ш	8	35000	280000
Canon LBP1120/EP22l	ш	4	40000	160000
HP laserjet 2300	ш	3	30000	90000
HP laserjet M132 l19A	ш	5	45000	225000
HP laserjet 1018 l12A	ш	5	35000	175000
HP M12A l79a	ш	3	40000	120000
Canon MFP lс32B	ш	5	45000	225000
HP1102 l85a	ш	5	45000	225000
Epson l1800 өнгөт100гр хор	6 хос хор	4	27000	108000
Цэнэглэгч хор Самсунг	ш	20	6000	120000
Цэнэглэгч хор HP	ш	20	6000	120000
Canon NPG-51	ш	4	40000	160000
Canon NPG-59	ш	4	40000	160000
Цаасны цавуу 8гр	ш	40	800	32000
Тамганы тос	ш	10	1500	15000
Баримт ар	ш	500	700	350000
Үдээсний сум	ш	50	700	35000
			Нийт	9715000

Захирал



А.Мөнхцэцэг

Агвааншарав МӨНХЦЭЦЭГ

Анарпринт

Захиргаа

Захирал

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХӨВСГӨЛ ХОНГОР
ХХК**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандосол баг
Утас: 99442213
Э-мэйл: tungaaz7308@gmail.com

2020.02.11 № 1/67
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Х.ГАН-ОЧИР ТАНАА**

ҮНИЙН САНАЛ

1. Бид "Хөвсгөл Хонгор" ХХК, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ БИЧИГ ХЭРЭГ, ХЭВЛЭМЭЛ ХУУДАС НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ХӨАЗДТГ/202001001/01/01 дугаартай тендерийн Багц -2-ыг дор дурдсан үнээр:

..... **3 461 300** (тоогоор) *Гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга гурван зуун төг 00 мөн*

..... (үсгээр) төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй.

4. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогч:

Эрх бүхий албан тушаалтны
гарын үсэг, тамга

Албан тушаал, нэр

Хаяг:



Захирагч В.Ганзориг

Мөрөн сум 8-р баг

